



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 453

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 16 дугаар зүйлийн 16.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.2.8, 2.2.9, 3.2, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2006 оны 392/90, 2007 оны “Хавсран ажил гүйцэтгүүлэх тухай” 330/108 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллийг аймаг, нийслэл, дүүрэгт хэрэгжүүлэх журам”-ыг 1 дүгээр, төлөөлөгчийн ажлын тоон мэдээ, салбарын мэдээлэл, тайлангийн маягтуудыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, бүртгэлийн мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, төлөөлөгчийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2017 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн
453 тоот тушаалын 1 дүгээр хавсралт



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТӨЛӨӨЛЛИЙГ АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРЭГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны төлөөллийг аймаг, нийслэл, дүүрэгт хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2. Төлөөллийг Хорооноос томилогдсон этгээд /цаашид “Төлөөлөгч” гэх/ хэрэгжүүлнэ.
- 1.3. Дараах албан тушаалтныг төлөөлөгчөөр томилно:
 - 1.3.1. аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
 - 1.3.2. аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн;

Хоёр. Төлөөлөгчийг томилох, чөлөөлөх

- 2.1. Төлөөлөгч нь төлөөллийг хэрэгжүүлэхдээ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтлахаас гадна дараах зарчмыг баримтална:
 - 2.1.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай, Хоршооны тухай, Компанийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиуд, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгох;
 - 2.1.2. үндсэн чиг үүргийн болон төлөөллийн үйл ажиллагааны тэнцвэрийг хангах;
 - 2.1.3. санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх;
 - 2.1.4. санхүүгийн бие даасан байдлыг хангах;
- 2.2. Төлөөлөгчөөр томилогдох этгээд нь:
 - 2.2.1. төрийн захиргааны албан хаагч байх;
 - 2.2.2. төрийн албан тушаалд томилсон шийдвэр гарсан байх;

2.3. Энэхүү журмын 1.3.1, 1.3.2-г заасан албан тушаалтныг тухайн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор дараах материалыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.Үүнд:

2.3.1. Хорооны төлөөлөгчөөр томилуулах хүсэлт бүхий Засаг даргын албан тоот;

2.3.2. Сүүлийн 6 сард авхуулсан 3*4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;

2.3.3. Төрийн албан хаагчийн анкет;

2.3.4. Ажилд томилсон болон өмнөх төлөөлөгчийг чөлөөлсөн тушаалын хуулбар.

2.4. Төлөөлөгчийг томилох, чөлөөлөх шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн эрх бүхий этгээдийн санал болгосноор Хорооны дарга гаргана.

Гурав. Төлөөлөгчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тайлан гаргах

3.1. Төлөөлөгч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэр, Хорооны дунд болон урт хугацаанд баримтлах бодлого, дүрэм, журмын биелэлтийг хангуулах;

3.1.2. Зохицуулалтын байгууллагууд, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, мэргэжлийн оролцогчдын нэгдсэн бүртгэл хөтлөх;

3.1.3. Хорооноос баталсан удирдамжийн дагуу дээрх байгууллага, мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаанд жил бүр, шаардлагатай тохиолдолд хагас жил тутам шалгалт хийх;

3.1.4. Хорооны улсын байцаагчаас зохицуулалтын байгууллагуудад хүргүүлсэн албан шаардлагын биелэлтийг хангуулах, энэ талаарх тайланг тухай бүр Хороонд ирүүлэх;

3.1.5. Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг Хороо, эсхүл зохицуулалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.1.6. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн орон нутагт хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээ авах, шаардлагатай гэж үзэн Хороонд хүргүүлэх бол холбогдох нотлох баримт бичгийн бүрдлийг гүйцэд гаргацтай бүрдүүлүүлж шилжүүлж байх; (Маягт 4)

3.1.7.Банкнаас бусад санхүүгийн салбарт баримтлах стратеги, бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутагт хийгдэж байгаа судалгааны үйл явцыг хянаж холбогдох мэдээллийг Хороонд хүргүүлэх;

3.1.8.Тусгай зөвшөөрөл хүссэн байгууллагад газар дээрх үзлэг хийлгэхээр Хорооны бүртгэл зөвшөөрлийн нэгжээс төлөөлөгчид хандсан тохиолдолд холбогдох мэдээллийг маягтын дагуу бэлтгэж хүргүүлэх;

3.1.9.Хорооны зохицуулалтын салбарын ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, холбогдох мэдээллийг Хороонд тухай бүр ирүүлэх;

3.1.10. Банкнаас бусад санхүүгийн чиглэлээр орон нутагт хэрэгжүүлэх зохицуулалтын үйлчилгээний асуудлаар судалгаа, дүгнэлт хийж санал боловсруулж танилцуулах.

3.2. Төлөөлөгч нь чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд дараах эрхийг эдэлнэ:

3.2.1. Хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэх;

3.2.2. Хорооноос олгосон үнэмлэх хэрэглэх;

3.2.3. Нэмэгдэл хөлс авах;

3.2.4. Нэвтрэх нэр, нууц үг ашиглан Хорооны цахим хуудсанд нэвтэрч мэдээлэл солилцох;

3.2.5. Харьяалах орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа зохицуулалтын байгууллагуудаас мэдээлэл, судалгаа, тайлан гаргуулан авах, шаардлага тавих.

3.3. Төлөөлөгч нь дараах үүргийг хүлээнэ:

3.3.1. Хагас жилийн ажлын тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор(Маягт 1) гаргаж Хороонд хүргүүлэх;

3.3.2. Жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын сарын 30-ны өдрийн дотор гаргаж Хороонд хүргүүлэх(Маягт 3);

3.3.3. Орон нутгийн зохицуулалттай этгээд, тэдгээрийн салбар нэгжийн байршил, ажлын байрны стандартын шаардлага хангасан эсэх талаарх мэдээллийг тайланд тусгах (Маягт 2);

3.3.4. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэх, тайлбарлах;

3.3.5. Төлөөлөгч ажлаас чөлөөлөгдсөн даруй Хорооны төлөөлөгчийн ажлын үнэмлэхийг Захиргаа удирдлагын газарт хүлээлгэн өгнө.

3.4. Төлөөлөгчид олгох нэмэгдэл хөлсний хэмжээг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар тогтооно.

Дөрөв. Хорооны чиг үүрэг

4.1. Аймаг, нийслэл, дүүрэг дэх төлөөллийн үйл ажиллагаатай холбогдуулан Хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Төлөөлөгчөөр томилогдох этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх, төлөөлөгчөөр томилох, чөлөөлөх;

4.1.2 Төлөөлөгч, тэдгээрийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хөтлөх;

4.1.3. Төлөөлөгчөөр томилогдсон тухай бүр хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдуулан нарийвчилсан зааварчилгаа өгөх, тэдэнд зориулсан тэнхимийн, зайны сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах;

4.1.4 Төлөөлөгч үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн даруйд хэвлэмэл хуудас, тэмдгийг шинээр томилогдсон төлөөлөгчид хүлээлцүүлэх арга хэмжээ авах;

4.1.5. Хорооны цахим хуудсанд нэвтрэх, мэдээлэл солилцох боломжоор төлөөлөгчийг хангах;

4.1.6. Орон нутагт шинээр тусгай зөвшөөрөл, салбарын зөвшөөрөл авсан зохицуулалтын байгууллагын мэдээллийг төлөөлөгчид тухай бүр хүргүүлэх, тусгай зөвшөөрөл олгосон, тусгай зөвшөөрлийг нь цуцалсан этгээдийн бүртгэлд тулгалт хийх;

4.1.7. Төлөөлөгчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүн, тайланг нэгтгэн Улсын Их Хуралд хүргэх.

4.2. Төлөөлөгчийн ажлын төлөвлөгөө, ажлын гүйцэтгэлийн үр дүнг дүгнэж урамшуулал олгож болно.

4.3. Чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзвэл төлөөлөгчид нэмэгдэл хөлсийг нь олгохоос татгалзах саналыг харьяа Засаг даргад хүргүүлж болно.

Тав. Хариуцлага

5.1 Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2017 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн
453 тоот тушаалын 2 дугаар хавсралт



**МАЯГТ 1 ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
АЖЛЫН ТООН МЭДЭЭ**

Хийсэн ажлын чиглэл		Тоо
Нэг: Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээр		
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХК-ийн тоо	
2	Хувьцаат компаниудын үйл ажиллагаанд тавьсан хяналт Хороотой хамтарсан/ дангаар	
3	Үйл ажиллагаа нь бүр мөсөн зогссон ХК-ийн тоо	
4	ХК-иудын санхүүгийн тайлан Хороонд ирүүлсэн байдал /улирал, хагас, бүтэн жилээр/	
5	ХК-иудын ТУЗ-ийн хурал, Хувьцаа эзэмшигчдийн хурал хийсэн байдал	
6	ХК-иудын ноогдол ашиг тараалтын байдал	
7	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Брокер, дилерийн компанийн тоо	
8	Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаанд тавьсан хяналт, шалгалтын тоо. Хороотой хамтарсан/ дангаар	
9	Хөрөнгийн зах зээлийн талаар олон нийтэд сурталчилсан байдал /орон нутгийн телевиз, "fm" радио, сонин хэвлэл, өдөрлөг .../ гэх мэт	
10	ХК, БДК-уудын талаар гаргасан иргэдийн хүсэлт, санал, гомдлын тоо /шийдвэрлэсэн байдал/	
Хоёр. Даатгалын мэргэжлийн оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээр		
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газрын тоо	
2	Даатгалын мэргэжлийн оролцогчдын тоо: Үүнд: Даатгалын зуучлагчийн тоо Даатгалын хохирол үнэлэгчийн тоо Даатгалын төлөөлөгчийн тоо	
3	Даатгалын төлөөлөгчийн шалгалтад оролцсон хүний тоо / тэнцсэн хүний тоо	
4	Даатгалын чиглэлээр хийсэн хяналт шалгалтын тоо. Хороотой хамтарсан / дангаар	
5	Даатгагч болон Даатгуулагч нараас тавьсан хүсэлт, санал гомдлын тоо / шийдвэрлэсэн байдал	
6	Даатгалын зах зээлийн талаар олон нийтэд сурталчилсан байдал /орон нутгийн телевиз, "fm" радио, сонин хэвлэл, өдөрлөг.../гэх мэт	
Гурав. Банк бус санхүүгийн байгууллагын чиглэлээр		

1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагын тоо	
2	Банк бус санхүүгийн байгууллагад хийсэн хяналт шалгалтын тоо Хороотой хамтарсан / дангаар	
3	Санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг хуульд заасан хугацаанд гаргуулан Хороонд ирүүлсэн байдал	
4	Банк бус санхүүгийн чиглэлээр иргэд олон нийтээс гаргасан хүсэлт, санал, гомдлын тоо /шийдвэрлэсэн байдал	
5	Банк бус санхүүгийн салбарын чиглэлээр олон нийтэд сурталчилсан байдал /орон нутгийн телевиз, "fm" радио, сонин хэвлэл, өдөрлөг.../г.м	
Дөрөв. Хадгаламж зээлийн хоршооны чиглэлээр		
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Хадгаламж зээлийн хоршоодын тоо	
2	Хадгаламж зээлийн хоршоодод хийсэн хяналт шалгалтын тоо Хороотой хамтарсан / дангаар	
3	Санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг хуульд заасан хугацаанд гаргуулан Хороонд ирүүлсэн байдал	
4	Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны чиглэлээр тавьсан хүсэлт, санал гомдлын тоо/ шийдвэрлэсэн байдал	
5	Хадгаламж зээлийн хоршооны чиглэлээр олон нийтэд сурталчилсан байдал / "fm"радио, орон нутгийн телевиз, сонин хэвлэл, өдөрлөг г.м	
Тав. Хөдөө аж ахуйн биржийн чиглэлээр		
1	ХААБ-ийн арилжаа зуучлагчдын тоо	
2	ХААБ-ийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын тоо, Хороотой хамтарсан/дангаар	
3	Санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг хуульд заасан хугацаанд гаргуулан Хороонд ирүүлсэн байдал	
4	ХААБ-ийн арилжаа хийгдсэн тоо	
Зургаа. Зохион байгуулсан сургалт		
1	Үнэт цаасны чиглэлээр хийсэн сургалтын тоо/ хамрагдсан хүний тоо	
2	Даатгалын чиглэлээр хийсэн сургалтын тоо/ хамрагдсан хүний тоо	
	2.1 Даатгалын хохирол үнэлгээчний сургалт	
	2.2 Даатгалын зуучлагчийн сургалт	
	2.3 Даатгалын төлөөлөгчийн сургалт	
3	Банк бус санхүүгийн байгууллагын чиглэлээр хийсэн сургалтын тоо/ хамрагдсан хүний тоо	
4	Хадгаламж зээлийн хоршооны чиглэлээр хийсэн сургалтын тоо/ хамрагдсан хүний тоо	
5	ХААБ-ийн чиглэлээр хийсэн сургалтын тоо/ хамрагдсан хүний тоо	
Долоо. Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлт		
1	Албан бичгээр өгөгдсөн үүрэг даалгаврын тоо/биелэлт	
2	Улсын байцаагчийн албан шаардлагын тоо/ биелэлт	



Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2017 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн
153 тоот тушаалын 2 дугаар хавсралт

УХА0410 5043239

Маягт 2 -т үйл ажиллагаа эрхэлж буй зохицуулалттай этгээдийн салбарын дэлгэрэнгүй бүртгэл

№	Байгууллагын нэр	Тухайн орон нутагт		Ажлын байрны нөхцөл		Мэргэжлийн болон санхүүгийн програмы хангамжтай эсэх	Салбарын санхүүгийн эрх	Стандарт хаягжуулалт		Ажилтны тоо /Сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авсан байх/			Харилцаа холбоо			Хяналтын камерийн систем	Салбарын автомашин	Интернэт	Банкны данс	
		Үндсэн	Салбар	Өөрийн байранд	Түрээсийн байранд			Гадна хаяг	Доторх хаяг	Үндсэн	Гэрээт	Албаны утас	Гар утас	Цахим хаяг						
1. Үнэт цаас																				
1.1																				
1.2																				
2. Даатгал																				
2.1																				
2.2																				
3. ББСБ																				
3.1																				
3.2																				
4. ХЗХ																				
4.1																				
4.2																				
5. ХААБ																				
5.1																				
5.2																				

Бүртгэл судалгаа хийсэн: _____ / Гарын үсэг / _____ Нэр / _____ Огноо
Төлөөлөгч

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2017 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн
453 тоот тушаалын 2 дугаар хавсралт



Маягт 3 ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
БИЧВЭР ТАЙЛАН

Нэг. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээр
Тайлан бичих талбар
Хоёр. Даатгалын салбар болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээр
Тайлан бичих талбар
Гурав. Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээр
Тайлан бичих талбар
Дөрөв. Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны чиглэлээр
Тайлан бичих талбар
Тав. Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны чиглэлээр
Тайлан бичих талбар
Зургаа. Хорооноос өгсөн үүрэг даалгавар, улсын байцаагчийн албан шаардлагын биелэлт, сургалтын тайлан
Тайлан бичих талбар

Тайлан бичсэн:

Төлөөлөгч:

Гарын үсэг // Нэр // Огноо /...../

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2017 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн
453 тоот тушаалын 2 дугаар хавсралт



Маягт 4 ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ОРОН НУТАГТ ИРСЭН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ МЭДЭЭ

№	Өргөдөл гаргагч байгууллага, Иргэний нэр	Өргөдөл гаргасан зохицуулалтай этгээдийн нэр	Өргөдөл, гомдлын утга	Хүлээн авч орон нутагт шийдвэрлэсэн тохиолдолд бөглөнө.			Хороогоор шийдвэрлүүлэхээр илгээсэн албан тоотын огноо, дугаар
				Өргөдөл, гомдол ирүүлсэн Огноо	Хэрхэн шийдвэрлэсэн тухай	Хариу өгсөн огноо	
1							
2							
3							
4							
5							

Төлөөлөгч /Гарын үсэг / /Овог, нэр / огноо